



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 1 дүгээр
сарын 5-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг олон нийтэд сурталчлан таниулж, хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга нарт, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 45 дугаар тогтоол, "Журмын хавсралтыг өөрчлөн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 118 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Монгол Улсын Шадар сайд

С.АМАРСАЙХАН



Засгийн газрын 2022 оны 1 дүгээр тогтоолын хавсралт

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНД ҮНДЭСЛЭН ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журам нь коронавируст халдвар /КОВИД-19/ (цаашид "халдвар" гэх)-ын тархалтын түвшин, дархлаажуулалтын хамралт, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн уг халдварын үеийн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулахдаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах зарчим баримтална.

1.3.Энэ журамд заасан хуулийн этгээд гэдэгт Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасныг ойлгоно.

Хоёр.Халдварын тархалтын түвшин

2.1.Халдварын тархалтын үе шат нь дараахь түвшинтэй байна:

- 2.1.1.ногоон түвшин;
- 2.1.2.шар түвшин;
- 2.1.3.улбар шар түвшин;
- 2.1.4.улаан түвшин.

2.2.Халдварын тархалтын түвшинг тодорхойлох түр зааврыг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Гурав.Зохион байгуулалтын арга хэмжээ

3.1.Халдварын тархалтын түвшинг тогтоосон үнэлгээний тайланг Халдварт өвчин судлалын үндэсний төв, аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар 7 хоног бүр тогтоож, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны онцгой комисст тус тус хүргүүлнэ.

3.2.Эрүүл мэндийн байгууллагын санал, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, орон нутгийн онцлог, эмнэлгийн тусламж, үйлчилгээний нөөц, хүчин чадлаас хамаарч коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны горимд нийцүүлэн тухайн шатны онцгой комисс хариу арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3.3.Стратегийн ач холбогдол бүхий салбар, бүс нутагт хүн, хуулийн этгээдийн хэрэгжүүлэх арга хэмжээг шаардлагатай тохиолдолд Улсын онцгой комисс тогтооно.

3.4.Халдварын тархалтын түвшинг харгалзан бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх эсэх асуудлыг аймаг, нийслэлийн онцгой комисс боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөнөөр шийдвэрлэнэ.

Дөрөв.Халдварын тархалтын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

4.1.Халдварын тархалтын түвшинтэй уялдуулан бүх шатны онцгой комисс дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

4.1.1.“Ногоон түвшин”-д хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлахгүй, нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана;

4.1.2.“Шар түвшин”-д бүх төрлийн үйл ажиллагааг хязгаарлахгүйгээр Улсын онцгой комиссоос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг мөрдөж ажиллана;

4.1.3.“Улбар шар түвшин”-д хариуцлагын гэрээ байгуулж хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тодорхой хүрээнд хязгаарлана;

4.1.4.“Улаан түвшин”-д нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг тогтоож, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулна.

4.2.Халдварын тархалтын түвшин бүрт хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг энэ журмын хавсралтад заасан горимоор зохицуулна.

4.3.Хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралтад заасан горимын дагуу үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийг баримтлан ажиллана.

Тав.Хариуцлага

5.1.Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын тархалтын түвшинд хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журмын хавсралт

ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

НЭГ. ХУВЬ ХҮН, ГЭР БҮЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Түвшин	I			II		III		IV	
	Ногоон түвшин (Тархалт бага тогтвортой)	Шар түвшин (Зөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай)	Улбар шар түвшин (Халдвар голомтот тархалттай)	Улаан түвшин (Халдвар хүн амын дунд тархсан)					
Хувь хүн, гэр бүл	Хязгаарлах үйл ажиллагаа								
	Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах	<ol style="list-style-type: none"> Халдварын тархалт өндөртэй бус нутаг руу зорчихгүй байх; Ойрын хавьтал болсон эсвэл халдвар батлагдсан хүнтэй уулзахгүй байх; Өндөр настан, бага насны хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүд, архаг хууч өвчтэй хүн олон нийтийн газраар аль болох явахгүй байх. 	<ol style="list-style-type: none"> Зочин урихгүй, айлд зочлохгүй байх; Олон хүн цугларсан газарт аль болох очихгүй байх; Хавьтал болсон үед нийгмийн харилцаанд орохгүй байх; 12-оос доош насны хүүхдийг 18 цагаас хойш зохион байгуулах олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй байх; Зөвхөн гэр бүл, хамаатан, садны хүмүүсийн оршуулгын үйл ажиллагаанд оролцох. 	<ol style="list-style-type: none"> Эмнэлгийн зайлшгүй тусламж, эмийн сангаар үйлчлүүлэх; Өмгөөлөл, нотариатаар үйлчлүүлэх; Оршин суугаа хорооны хүнсний дэлгүүр, борлуулалтын цэг, худгаас хүнс, ахуйн хэрэглээний бараа, түлш, зөөврийн ус авах; Газар тариалан эрхлэх; Оршуулгын үйл ажиллагаанд оролцох. 					
Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах	Хязгаарлалтаас хамаарч тавигдах шаардлага								
	<ol style="list-style-type: none"> Шаардлагатай үед амны хаалт зүүх; Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих. 	<ol style="list-style-type: none"> Олон нийтийн газар, дотоод орчинд амны хаалт зүүх; Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих; Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг сахих; 	<ol style="list-style-type: none"> Олон нийтийн газар, дотоод орчинд амны хаалт зүүх; Хүн хооронд 1,5-2 метрээс доошгүй зай барих; Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг сахих; "Гэр-ажил-гэр" "Гэр-сургууль-гэр" зарчим баримтлах; Шинж тэмдэг илэрсэн 	<ol style="list-style-type: none"> Гэрээс гарахгүй байх зарчмыг баримтлах; Гадаад, дотоод орчинд амны хаалт зүүх; Нэн шаардлагатай хүнс, эм, түлш, ус худалдан авахаар айл, өрхөөс 1 хүн гарах; Айлд зочлохгүй, зочин урихгүй байх; Хүн хооронд 2 метрээс доошгүй зай 					

	4. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд угсаар зөвлөгөө авах, өөрийгөө тусгаарлах, өөрийгөө тусгаарлах, дэглэм сахих.	тохиолдолд угсаар зөвлөгөө авах, өөрийгөө тусгаарлах, дэглэм сахих.	барих; 6. Мэргэжлийн байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийг баримтлах; 7. Төрөөс зохион байгуулж байгаа халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцох; 8. Шинж тэмдэг илэрсэн тохиолдолд 100, 119 дүгээр угсаар зөвлөгөө авах.
Дархлаажуулалт Зорчих хөдөлгөөн	1. Дархлаажуулалтын тухай хуулийн 6.2.1-д "Эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шаардлагын дагуу сэргийлэх тарилга хийлгэх үүрэг хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлэх; 2. Дархлаажуулалтад товлонт хугацаанд хамрагдах; 3. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эсрэг дархлаажуулалтад хамрагдсаныг нотлох баримт, магадлагааг цахим болон цаасан хэлбэрээр авч явах.	1. Хүн хоорондын зай барих; 2. Нэг суудал алгасч суух; 3. Халдвараас сэргийлэх дэглэм сахих; 4. Эрсдэлт бүлгийн хүн ам (өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт) нийтийн тээврийн үйлчилгээний оргил цагаар аль болох зорчихгүй байх.	1. Зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд зорчихгүй байх; 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягтай зорчих; 3. Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх; 4. Цахилгаан шат аль болох ашиглахгүй байх; 5. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай зорчих.
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтрэх	1. Халдвараас сэргийлэх дэглэм сахих; 2. Шаардлагатай тохиолдолд асуумж өгч нэвтрэх.	1. Халдвараас сэргийлэх дэглэм сахих; 2. Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх.	1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягтай нэвтрэх; 2. Хязгаарлалтад хамаарахгүй үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн холбогдох бичиг баримттай нэвтрэх; 3. Товчооны гадна ажиллаж, амьдардаг хүн байнга оршин суугаа газрын баг, хорооны

				<p>тодорхойлолтой нэвтрэх;</p> <p>4. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай нэвтрэх.</p>
--	--	--	--	--

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДэд ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОРИМ

Түвшин	I			III		IV Улаан түвшин (Халдвар хүн амьн дунд тархсан) Хязгаарлахгүй үйл ажиллагаа
	Ногоон түвшин (Тархалт бага тогтвортой)	Шар түвшин (Зөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай)	Улбар шар түвшин (Халдвар голомтот тархалттай)	Хүчин чадлын 50 хувийг хязгаарлах		
Хуулийн этгээд	Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах	<ol style="list-style-type: none"> 1. Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах; 2. Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсан, түргэвчилсэн шинжилгээнд хамрагдаж сөрөг хариу гарсан ажилтан, уран бүтээлч, үйлчлүүлэгч нарыг оролцуулах. 	<ol style="list-style-type: none"> 1. Бүх төрлийн баяр ёслол, тэмдэглэлт ойн арга хэмжээ, хурал, цуглаан, цайллага, хүлээн авалт, хурим, найр; Биений тамир, спортын үйл ажиллагаа; 3. Соёл, урлагийн арга хэмжээ; 4. Аялал зугаалга (гэр бүлээс бусад); 5. Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар (Ресторан, кафе, сүлжээ хоолны газар, түргэн хоолны газар, кофе шол, цайны газар, буфет, явуулын үйлчилгээтэй хоолны газар); 6. Бүх төрлийн баар; 7. Хүнснээс бусад барааны зах, худалдааны төв; 8. Дотоод орчинд өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа; 9. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар; 10. Сургалтын төв; 11. Үзвэр үйлчилгээ; 12. Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв; 13. Саун, бассейн, нийтийн халуун ус, алжаал тайлах төв; 	<ol style="list-style-type: none"> 1. Хууль тогтоох, төрийн захиргааны байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Авлигатай тэмцэх газар; 2. Эрүүл мэндийн байгууллага; 3. Тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд (Байгаль орчныг хамгаалах, гааль, дипломат алба, онцгой байдал, мэргэжлийн хяналт, зөвсэгт хүчин бусад цэрэг, татвар, тусгай алба, гадаадын иргэн, харьяат, улсын бүртгэл, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, ИНЕГ түүний харьяа алба, салбар нэгж); 4. Шүүх, прокурор, өмгөөлөл, нотариат; 5. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, байгууллага; 6. Нисэх онгоцны буудал, агаарын тээвэрлэгчид; 7. Эрчим хүч, дулаан, усан хангамж, ариутгах татуурга, хот, нийтийн аж ахуй; 8. Шуудан, харилцаа холбоо; 9. Шатахуун, түлшний үйлдвэрлэл, хангамж, нийлүүлэлт, түгээлт, тусгай зөвшөөрөл бүхий 		

			<p>14. Амралт, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал; 15. Шашны зан үйл, сүм, хийд, мөргөлийн газрууд.</p> <p>байгууллагын түлшний тээвэрлэлт, худалдаа; 10. Геологи, хайгуул, уул уурхай, газрын тосны олборлолт; 11. Хоол үйлдвэрлэл, түгээлт (зөвшөөрөл бүхий); 12. Зайны сургалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ, асрамж, халамж, түр хамгаалах байр; 13. Монголын улаан загалмай нийгэмлэг; 14. Газар тариалан, мал, амьтны өвс, тэжээлийн түгээлт, тээвэрлэлт; 15. Хүний болон малын эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага; 16. Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт, сав баглаа боодол; 17. Банк, автомат тооцооны машин; 18. Тусгайлан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа (эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр); 19. Хэвлэл мэдээлэл (зөвшөөрөл бүхий); 20. Дугуй засварын газар; 21. Оршуулгын үйл ажиллагаа.</p>
Хязгаарлалтаас хамзарч тавигдах шаардлага			
Халдвараас сэргийлэх дэглэм баримтлах	<p>1. Шаардлагатай үед амны хаалт зүүх; 2. Хүн хоорондын зай барих.</p>	<p>1. УОК-оос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллах; 2. Байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлолт</p>	<p>1. Хариуцлагын гэрээ байгуулах (Төрийн байгууллагад хамаарахгүй); 2. Байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлолт тохируулан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх; 3. Албан бичиг, баримтыг цахимаар хүлээн авах.</p> <p>1. Ажлын тусгай горимд шилжүүлэх (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах); 2. Ажиллаж байгаа албан хаагчдын хоол үйлдвэрлэл, түгээлт (аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтоосон горимоор); 3. Шаардлагатай яам, агентлаг, байгууллага 24 цагаар тасралтгүй үүрэг гүйцэтгэх, шуурхай штабын</p>

		<p>тохируулан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;</p> <p>3. Улиралд нэг удаа урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэх;</p> <p>4. Халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй байх;</p> <p>5. Ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалах.</p>	<p>солилцох;</p> <p>4. Улиралд нэг удаа урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэх;</p> <p>5. Ажлын байранд зайлшгүй ирэх шаардлагагүй ажил үүргийг цахимаар гүйцэтгэх;</p> <p>6. Ойрын хавьтал, халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй байх;</p> <p>7. Ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалах;</p> <p>8. Хурал, цуглааныг цахимаар хийх;</p> <p>9. Цагийн хязгаарлалт тогтоож болно.</p>	<p>бүрэлдэхүүнийг томилж, Улсын онцгой комиссын Шуурхай штабтай мэдээ, мэдээлэл шуурхай солилцож ажиллах;</p> <p>4. Амны хаалт тогтмол зүүх;</p> <p>5. Мэргэжлийн байгууллагын зөвлөмж, шаардлагыг баримтлах;</p> <p>6. Орлон ажиллах ажилтныг томилон ажиллуулах;</p> <p>7. Албан бичиг, баримтыг цахимаар хүлээн авах, солилцох;</p> <p>8. Хурал, цуглааныг цахимаар зохион байгуулах;</p> <p>9. Нэг өрөөнд 3-аас дээш ажилтан, албан хаагч хамт ажиллахгүй, хооллохгүй байх;</p> <p>10. Ажлын байранд өдөрт 2 удаа чийттэй цэвэрлэгээ хийх;</p> <p>11. Өрөө, тасалгаанд агаар салгалт хийх;</p> <p>12. Стратегийн хүнсний бүтээгдэхүүний сав баглаа, боодлын үйлдвэрийн хангамж, нийлүүлэлт болон хүнсний салбарын ажилчдын ажлын хуваарь, зорчих хөдөлгөөнийг зохицуулах;</p> <p>13. Тусгайлсан сав баглаа, боодолтой хүнсний бүтээгдэхүүнийг цахим захиалгын дагуу гараас үүдэнд хүргэх, авах.</p>
Дархлаажуулалт	Дархлаажуулалтын тухай хуулийн 7.2-т "Аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажилтнуудыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээнэ" гэж заасныг хэрэгжүүлэх	<p>1. УОК-оос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл мөрдөж шаардлагыг мөрдөж ажиллах;</p> <p>2. Халдвараас сэргийлэх</p>	<p>байгууллага нь өөрийн ажилтнуудыг хэрэгжүүлэх</p> <p>1. Нэг суудал алгасч суулгах тэмдэглэгээ тавих, мөрдөх;</p> <p>2. Нийтийн тээврийн хэрэгслийг өдөрт нэг удаа цэвэрлэх, агаар сэлгэлт хийх;</p> <p>3. Хүн хоорондын зай баруулах;</p> <p>4. Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах;</p> <p>5. Халдвараас урьдчилан</p>	<p>УОК-оос гаргасан шийдвэрийг дагаж мөрдөх</p> <p>1. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар тусгайлан заасан чиглэл, маршрут, цагийн хуваарьт шилжүүлэх;</p> <p>2. Суудал алгасч 1 зорчигч суулгах;</p> <p>3. Хүн хоорондын зай барих;</p> <p>4. Халдвараас сэргийлэх дэглэм сахиулах;</p> <p>5. Халдвараас урьдчилан сэргийлэх</p>
Нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлж буй байгууллага	Халдвараас сэргийлэх баримтлан дэглэм ажиллах.			

	дэглэм ажиллах:	баримтлан	сэргийлэх сурталчилгааг тогтмол хийх.	сурталчилгааг тогтмол хийх; Хяналтын байцаагч ажиллуулах.
Зорчих хөдөлгөөн	Халдвараас сэргийлэх дэглэм сахих	<ol style="list-style-type: none"> 1. Аль болох хувийн унаагаар зорчих; 2. Нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо халдвараас сэргийлэх дэглэм баримтлах. 	<ol style="list-style-type: none"> 1. Аль болох хувийн унаагаар зорчих; 2. Хүн хоорондын зай барих; 3. Нэг суудал алгасч суух; 4. Халдвараас сэргийлэх дэглэм сахих; 5. Эрсдэлт бүлгийн хүн ам (өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт) нийтийн тээврийн үйлчилгээний оргил цагаар аль болох зорчихгүй байх. 	<ol style="list-style-type: none"> 1. Зайлшгүй шаардлагаас бусад тохиолдолд зорчихгүй байх; 2. Хязгаарлалтад хамаарахгүй байгууллагын ажилтан, албан хаагчид байгууллагын тодорхойлолт, ажлын үнэмлэхтэй (аймгийн нутаг дэвсгэрт); 3. Нэг суудал алгасч суух; 4. Халдвараас сэргийлэх дэглэм сахих; 5. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хүн "А13", "Б13" маягтай зорчих; 6. Оршуулгын үйл ажиллагаанд оролцох хүн эмнэлгийн нас барсны гэрчилгээ, төрөл садны холбоог батлах лавлагаатай зорчих.
Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо	Халдвараас сэргийлэх дэглэм сахих.	<ol style="list-style-type: none"> 1. Шаардлагагай тохиолдолд асуумж авч нэвтрүүлэх; 2. Халдвараас сэргийлэх дэглэм сахих. 	<ol style="list-style-type: none"> 1. Орох гарах тээврийн хэрэгслийг хаагаарлах; 2. Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх. 	<ol style="list-style-type: none"> 1. Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх; 2. Албан томилолт, зайлшгүй шаардлагагай тээврийн хэрэгслийг улс, аймаг, нийслэлийн Онцгой комиссын шийдвэрээр нэвтрүүлэх.

Жич:

-Боловсролын байгууллагын үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл, шаардлагыг Улсын онцгой комисстой зөвшилцсөнөөр боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

-Хилийн нэвтрэх цэгт баримтлах үйл ажиллагааны горимыг Улсын онцгой комисс тогтооно.

-Дээрх хүснэгтэд дурдагдаагүй салбарын үйл ажиллагаа халдвараас сэргийлэх дэглэм баримтлан бүх түвшинд явагдана.